



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/340

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.6, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд болон “Ковид-19 цар тахал”-ын нөхцөл байдалтай холбогдуулан, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, орон нутгийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор аймгийн газар тариалан эрхлэгчдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэхэд зориулан 2,442,842 (хоёр сая дөрвөн зуун дөчин хоёр мянга найман зуун дөчин хоёр) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 2,442,842 (хоёр сая дөрвөн зуун дөчин хоёр мянга найман зуун дөчин хоёр) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Хүнсний ногооны үрийн чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах, аймгийн тариаланчдад технологийн хугацаанд нь хуваарилан олгох, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100727